

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2020 оны 100 дугаар тушаалын  
7 дугаар хавсралт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2022.12.06

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Жилийн эцэс		
1	2	3	4	5	6	7	8	9
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.</b>								
1	<b>Зорилт 1</b> Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна.	Улсын төсөв, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	- Цахим үйлчилгээний тоо - Шинээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн тоо	26 17	<b>30</b> <b>2</b>	<b>30</b> <b>2</b>	И-Монгол системээр дамжуулан хүргэх төрийн үйлчилгээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, ХЭНэрийн баталгаажуулалт нэмэгдсэнийг иргэдэд сурталчилж зааварчилгааг хүргэж цахимаар үйлчилгээ үзүүлж байна. Гадаад паспортын бүртгэлийн программ бичигдэж И-монголоор захиалж эхэллээ. Цахим үйлчилгээний тоо 32, Шинээр нийлүүлсэн тоног төхөөрөмж нийт 3 /Гадаад паспортын зураг авах зургийн аппарат 2ш, ХУБайцаагид олон үйлдэлт принтер/	<b>100</b>

1.1	<p><b><u>Арга хэмжээ 1</u></b></p> <p>Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах</p>		<p>-Тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг хангасан эсэх; - Иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо.</p>	0	6000	15000	<p>- Тус аймгийн 15 сумын бүртгэгчийн сүлжээ, тоног төхөөрөмжийн тохиргоог бүрэн хийж сумдын Засаг дарга, бүх байгууллага аж ахуйн нэгжийн дарга нарт аймгийн засаг даргын хугацаатай үүрэг бүхий албан тоотыг 2 удаа хүргэж ИБТасгийн даргын баталсан графикайн дагуу тоон гарын үсгийг олгосон. Явцын дунд аймгийн удирдлагын шуурхай хуралдаанаар сумдын тоон гарын үсэг олголтын мэдээг 3 удаа хэлэлцэн идэвхжүүлсэн.</p> <p>- Тоон гарын үсгийг олгох програмын болон хуулийн сургалтад ХУБайцаагч болон 18 бүртгэгч бүрэн хамрагдсан. Сумдын бүртгэгч нарт програмын зааврыг онлайн аар 3 удаа өгч сургалтанд хамруулсан. Мэдээллийг 15 сумдын удирдлага, агентлагийн дарга нийт 75 удирдах албан тушаалтанд 2 удаа өгч ажилласан.</p> <p>Тус аймаг 16 аас дээш насны 32044 иргэнд тоон гарын үсэг олгоно. Тоон гарын үсгийг бүртгэлийн 16 нэгжээр дамжуулан олгож байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 10982 иргэн буюу 34,0 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 9753 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1129 иргэнд гар утасны gsign app- аар дамжуулан олголоо.</p>	100
1.2	<p><b><u>Арга хэмжээ 2</u></b></p> <p>Анхан шатны нэгж дээр хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг</p>		<p>-Цахимжуулсан бүртгэлийн тоо.</p>	0		3000	<p>Иргэний улсын бүртгэгч нарт цахимжуулалтын нарийвчилсан зөвлөмж – 1 албан бичгээр, онлайн аар 3 удаа хийж 15 сумын бүртгэгч бүрэн хамрагдсан. Алдаатай цахимжуулсан зарим жишээг</p>	100

	цахимжуулах.				1400		<p>бодитоор таницуулан хэлтсийн ИБТАхлах бүртгэгч ажлын байранд тус бүр 2 хоног дадлага хийлгэж анхаарах асуудлыг биечлэн зааварчилсан.</p> <p>Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд иргэний гэр бүлийн 1212 бүртгэлийн 3771 хуудас, иргэний үнэмлэхийн 1766 бүртгэлийн 3000 хуудас, шилжилт хөдөлгөөний 1671 бүртгэлийн 3346 хуудас, гадаад паспортын 100 бүртгэлийн 100 хуудас нийт 4749 бүртгэлийн 10217 хуудас баримтыг цахимжуулсан байна.</p> <p>Иргэний Улсын бүртгэлийн газар, Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас 2022 оны 01 дугаар сарын 26- ны өдрийн “Баримт цахимжуулах тухай” 10/ 796 дугаар чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд 86 иргэний жагсаалт ирсэн.</p> <p>Тус ажлын хүрээнд 68 иргэний мэдээллийг шалгахад эцгийн мэдээлэл ороогүй 9, эхийн мэдээлэл ороогүй 52 бүртгэлийг оруулсан бөгөөд нийт 68 иргэний 80 ширхэг цаасан баримтыг цахим санд бүрэн цахимжуулсан.</p>	
1.3	<b>Арга хэмжээ 3</b> Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо;	0	0	0	2022 онд хууль, шүүхийн байгууллагад шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ороогүй бөгөөд тус байгууллагатай холбоотой шалгагдаж байгаа хэрэг байхгүй болно.	100
	<b>Зорилт 2.</b> Улсын бүртгэлийн	Байгуулл агын	Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн	<b>7838</b>		7900	2022 онд 13700 бүртгэлийг хуулийн хүрээнд үнэн зөв хийж мэдээллийн санд	100

	нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.	төсөв	бүртгэлийн тоо Бүртгэлийн үйлчилгээний талаарх өргөдөл, гомдлын тоо	2	4500 0	0	тусгасан байна. Сар бүр үйлчилгээний тоон мэдээг УБЕГазар, татварын хэлтэс гарган хүргүүлсэн. Үйлчилгээний талаар гомдол 7059106, засгийн газрын 11-11 төвд бүртгэгдээгүй байна.	
2.1	<b>Арга хэмжээ 1</b> Хууль тогтоомжийн дагуу хууль хяналтын байгууллагад улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа мэдээлэл хүргүүлэх.		Хууль хяналтын байгууллагад гаргасан лавлагаа мэдээллийн тоо	509	400	510	<b>Иргэний бүртгэлийн чиглэлээр:</b> Нийт 4589 лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр 396 лавлагаа хэвлэж олгосноос цагдаагийн байгууллагын хүсэлтээр 231, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр 152, Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн хүсэлтээр 13, лавлагааг тус тус олгосон. Нийт лавлагааны 14,7 хувийг хууль хяналтын байгууллагаас авч байгаа лавлагаа эзэлж байна. <b>ЭХЭУБүртгэлийн чиглэлээр:</b> Цагдаагийн газарт 46 тоотор 230 иргэний үл хөдлөх эд хөрөнгийн лавлагааг хамаарал бүхий иргэдийн лавлагаатай хамт гаргасан ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 39, иргэний эд хөрөнгийн дэлгэрэнгүй лавлагаа, Дундговь аймаг дахь ШШГГ 39 лавлагаа,эрх түдгэлзүүлэх 19, эрх сэргээх 17 бүртгэл хийж хувийн хэрэгт нь хавсарган архивт шилжүүлсэн. <b>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:</b> хууль хяналтын байгууллагад 26 лавлагааг гарган хүргүүлэв.Нийт 652 лавлагаа гаргасан байна.	100
2.2	<b>Арга хэмжээ 2</b>	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон				2022 онд хууль хяналтын байгууллагаас гадна 4255 иргэнд	100

	Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэдийн хүсэлтээр мэдээлэл, лавлагаа өгөх.		мэдээлэл, лавлагаа, хуулбар, нотлох баримтын тоо;	2183	1000	2200	лавлагаа гарган үйлчилсэн байна. Гэр бүлийн бүртгэлийн анхан шатны нотлох баримтын түвшинд албан хэрэгцээнд 286 лавлагаа хэвлэсэн байна.	
2.3	<b>Арга хэмжээ 3</b> Улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бичвэрийг цэгцлэх ажлыг зохион байгуулах.		Улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь цэгцэлсэн хаягийн бичвэрийн тоо.	0	50	50	ГХБХБГазартай хамтран 2020,2021 оны Иргэдийн хурлын тогтоолоор баталсан аймгийн төвийн 5 баг болон 15 суманд шинэ суурьшлын бүс үүссэнтэй холбоотойгоор иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын дагуу 66 гудамж, 5 байрны хаягийг УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар болон Мэдээлэл технологийн газарт жагсаалтыг хүргүүлэн хаягийн санд тусгууллаа	100
2.4	<b>Арга хэмжээ 4</b> Улсын бүртгэлийн үйлчилгээнд дундын мэдээллийн сан ашиглах	-	-ЭМГ-тай төрөлтийн бүртгэлийн мэдээлэл солилцсон тоо, тухайн оны төрөлтөөр	1250		төрөлтө өр	Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас регистрийн дугаарыг унагаж нийт 701 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг бүртгэсэн. Регистрийн дугаар зөрүүтэй олгогдсон 3 хүүхдийн бүртгэлийг нэгдсэн эмнэлэгт буцаан засварлуулж бүртгэлд хамрууллаа	100
2.5	<b>Арга хэмжээ 5</b> E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг тогтмолжуулах	200000 төсөв	И-Монголоор үйлчилгээ авсан иргэдийн тоо	56		100	Бүртгэлийн нээлттэй утсаар 2022 онд 1206 иргэн зөвлөгөө мэдээлэл авсан бөгөөд Поро бона сэдэвт тусгай чиг үүргийн байгууллагуудын нээлттэй мэдээллийн өдөр болон 15 сумдын малчдын өдөрлөгт оролцож e-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталыг нийт 972 иргэнд сурталчилж, утсанд нь тус e-mongolia аппикейшн суулгаж бүртгэлийн үйлчилгээ авах аргачлалыг зааж туршилт явуулж, иргэний үнэмлэхний лавлагааавахыг сургав. <b>E-mongolia</b> цахим үйлчилгээний нэгдсэн системээр иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 235 иргэнд иргэний үнэмлэх захиалан олгосон байна.	100

2.6	<p><b><u>Арга хэмжээ 6</u></b> Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах</p>	-	<p>-Сурталчилсан хэвлэл мэдээллийн хаягийн тоо;</p> <p>-Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо;</p>	2 36		2 40	<p>Орон нутгийн Говийн амьдрал сонинд 1, Өлзий телевизэд 1, цахим хаяг аймгийн хэмжээн 23 линкээр мэдээлэл дамжуулав.</p> <p>Хэлтсийн вэб сайтад текстэн мэдээ 110, видео мэдээ 22 бэлтгэн хөгжүүлэлт хийлээ. Үйлчилгээний сар бүрийн нэгтгэсэн тоон мэдээгээр 1 сараас 11-р сарын инфографик мэдээлэл бэлтгэн сар бүрийн 28-ны дотор олон нийтэд хүргэн, вэб сайтад байршууллаа.</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.19-д заасан арга хэмжээг заасан хугацаанд вэб сайт, фэйсбүүк пэйж хуудсанд нийт 150 мэдээг бэлтгэн, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор ханган ажиллалаа.</p>	100
2.7	<p><b><u>Арга хэмжээ 07</u></b> Дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.</p>	-	<p>- Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын мэдээлэл шалгах системд ажиллаж эхэлсэн эсэх</p>	0		10	<p>Аймгийн нотариатчидтай ажил хэргийн уулзалтыг 2 удаа зохион байгуулж бүртгэл авах бэлтгэл ажлыг хангах талаар чиглэл өгч ажилласан. УБ-ийн мэдээллийн санд өөрийн эрхээр нэвтрэн тухайн иргэний баримт бичгийг нягтлан шалгадаг болсон байна. Гадаад улсад хийгдсэн итгэмжлэлийн баримт бичгийг тойрог харгалзахгүй бүх нотариатын салбараас хүлээн авдаг болов.</p>	100
2.8	<p><b><u>Арга хэмжээ 8</u></b> Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг</p>	-	<p>-Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо;</p>	0		10	<p>УБЕГ -ын даргын 2022 оны 05сарын 30-ны өдрийн 6/4730 тоот чиглэлийн дагуу барьцааны гэрээ,барьцаалбар бүртгэх ЭУБ -06, ЭУБ-13 маягтууд ашиглан бүртгэл хийх талаар тасгийн хурлаар чиглэл өгч банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад хэлтсийн албан тоотоор чиглэл</p>	100

	хэрэглээнд нэвтрүүлэх.						хүргүүлж ажилласан. Банк санхүүгийн байгууллагын удирдлага, эдийн засагч нарт аймгийн Монгол банктай хамтран өглөөний уулзалт зохион байгуулж хамтын ажиллагааны талаар нарийвчилсан мэдээлэл солилцлоо. Улсын бүртгэлийн байгууллага барьцааны гэрээний хувийг авах, хадгалах шаардлагагүй цахимаар мэдээлэл дамжуулдаг болж үйлчилгээ шуурхай болсон. 2022 онд 135 бүртгэ хийгдэв.	
2.9	<b>Арга хэмжээ 9</b> Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлэх	-	-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо;  -Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоо.	1  23		1  100	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг Дэлгэрхангай сумын бүртгэгч эрх авснаар тус бүртгэгчийг дадлагжуулсан ба хэлтэс дээр гурав хоног бүртгэл хийлгэж дадлага хийлгэн тамга тэмдгийг нь хүлээлгэн өгч хил залгаа сумын бүртгэлийг бүртгэх бүрэн боломжтой болсон. ЭХЭУБүртгэлийн анхан шатны нотлох баримт, мэдүүлгийн хуудсыг 15 суманд хүлээн авч байна. 2022 оны 02 сарын 24 -нөөс бүртгэл хийж эхэлсэн. Эд хөрөнгийн бүртгэл хийх, цахимжуулах, мэдээ тайлан гаргах, үнэт цаасны тооцоо хийх, лавлагаа болон бусад үйл ажиллагааг хэвийн явуулж сурсан. Сумдад 2022 оны байдлаар 240 бүртгэл хийсэн байна.	100
2.10	<b>Арга хэмжээ 10</b> Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх.	-	-Сар бүрийн мэдээ буюу 12 удаа /Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архив, бичиг хэрэг, санхүү, хяналт/	12		12	Бүртгэлийн статистик тоон мэдээ, иргэний үнэмлэхийн мэдээ, санхүүгийн болон үнэт цаасны мэдээ зэргийг тус бүр 12 удаа гарган УБЕГ болон санхүүд хугацаанд нь гаргаж өгч тайлагнасан. Иргэний улсын бүртгэлийн статистик тоон мэдээнээс гадна сар бүр бичмэл тайлан гарган	100

							ИУБГазарт 12 удаа хүргүүлээ. Бүртгэлийн сар бүрийн статистик тоон мэдээгээр 1-12 дугаар сарын инфографик мэдээллийг бэлтгэн сайтад байршуулсан. 2022 онд Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архив, бичиг хэрэг, санхүү, хяналт чиглэлээр хоцорсон, тасалсан мэдээ байхгүй.	
2.11	<b>Арга хэмжээ 11</b> Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх	-	-Иргэний улсын бүртгэл хөтөлсөн тоо;  -Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо;  -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо.	9297  293  1297.		9300  294  1300	Иргэний бүртгэл: нийт 1766 иргэний үнэмлэх хэвлүүлж олгосноос шинээр 559, хаяж үрэгдүүлэн дахин авсан 314, хугацааны сунгалтаар 893 иргэнд иргэний үнэмлэх олгосон байна. Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд 701 хүүхэд, гэрлэлтийн бүртгэл 151, үрчлэлт 12, гэрлэлт цуцлалтын бүртгэл 34, эцэг тогтоолтын бүртгэл 24, ОНӨ бүртгэл 39, нас барсны бүртгэлд 251 нийт, 1671 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл, үндэсний энгийн гадаад паспорт 452 иргэн нийт 5101 бүртгэлийг мэдээллийн санд баталгаажуулсан байна. Нийт 4589 лавлагаа хэвлэсэн. Иргэний бүртгэлийн Үйлчилгээ <b>9690</b> <b>ЭХЭУБүртгэл: 2811</b> мэдүүлэг хүлээн авч бүртгэл хийснээс 915 анхны бүртгэл, эрх шилжүүлэх 483 бүртгэл, бүртгэлд өөрчлөлт 94, барьцааны гэрээ 1254, барьцааны гэрээ дуусгавар болох 596, лавлагаа 62-ийг бүртгэж, үйлчилгээний хураамж 19 680 195 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 101 737 961, тэмдэгтийн хураамж 2 013 552 төгрөг нийт улсын төсөвт 123 431 708 мянган төгрөгийн орлого орууллаа. <b>ХЭУБүртгэл:</b> • Дахин гэрчилгээ	100



						<p>олгосон-13 ХК 1, ХХК 72, Нөхөрлөл 2, Хоршоо 13, ХЗХ 5, Улсын төсөвт үйлдвэрийн газар 10, Төрийн бус байгууллага 5, Шашны байгууллага 2 нийт 183 хуулийн этгээдэд нэмэлт өөрчлөлт хийж</p> <p>Лавлагаа олгосон -15 Салбар төлөөлөгчийн газар бүртгэсэн -11 Хяналтын дугаар олгосон- шинээр ххк 88 , дахин олгосон 23 нийт 111 хяналтын дугаар Шашны байгууллага хугацаа сунгасан-2 Шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн ХХК 59 ,Нөхөрлөл 2, Хоршоо 7, Төрийн байгууллага албан газар 1, төрийн бус байгууллага 10, сан 1, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 1, нийт 264 бүртгэл хийж архивд 1334 хувийн хэрэг байршиж байна.</p>	
2.12	<p><b><u>Арга хэмжээ 12</u></b> Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалгасан тамга, тэмдгийг төрийн архивт шилжүүлэн хадгалуулах</p>	-	-Төрийн архивт шилжүүлсэн тамга тэмдгийн тоо.	0	1	<p>Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам"-д зааснаар Хяналтын дугаар олгосон шинээр ххк 88 , дахин олгосон 23 нийт 111 хяналтын дугаар татан буугдсан, хэлбэр өөрчилсөн, гэмтээсэн, нэр өөрчлөгдсөн шалтгаанаар тамга хураан авсан улсын төсөвт үйлдвэрийн газрын 16, ХХК 6, Салбар 1, ААТҮгазрын 1 нийт 24 тамга тэмдгийг хураан авсан байна. Холбогдох журмын дагуу төрийн архивт 16 тамга тэмдгийг актаар хүлээлгэн өгөв.</p>	100

	<b>Зорилт 3.</b> Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.	Байгуулл агын төсөв	- Хүчингүй болгосон үнэт цаасны тоо	227		200	Төлөвлөгөөт хяналтаар 21 бүртгэгчийн 4811 бүртгэлд хяналт хийж бүртгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй 200 үнэт цаасыг төлүүлж холбогдох мэдээллийг УБЕГазарт хүргүүллээ. 8 дүгнэлт гаргаж алдааг залруулав. 77500 төгрөгийг төвлөрүүлэв.	100
3.1.	<b>Арга хэмжээ 1</b> Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах		- Хяналт шалгалтын төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувиар	100%		100%	2022 онд хяналт шалгалтын төлөвлөгөөт , төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийхээр 8 заалт бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллалаа. 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан заалтын хэрэгжилтийг дэлгэрэнгүй тайланд тусгав. хэрэгжилт 100%,	100
3.2.	<b>Арга хэмжээ 2</b> Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд цахим хяналт нэвтрүүлэх	-	ЭХЭУБүртгэгч нарын 200 доошгүй бүртгэлд цахим хяналт хийх	0		200	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2811 бүртгэлд цахим хяналт хийж 8 дүгнэлт гаргаж холбогдох алдаа зөрчлийг арилгуулан 1 бүртгэгчид сахилгын шийтгэл ногдууллаа.	100
3.3	<b>Арга хэмжээ 3</b> Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх.	-	-Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн тоо; -Зөрчлийг зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэсэн тоо.	156		160	тайлант хугацаанд хялбаршуулсан журмаар 157 зөрчил шалган шийдвэрлэсэн. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 15.24.4 дэх заалт иргэний үнэмлэх хаяж, үрэгдүүлсэн 40 иргэн, Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх заалт иргэний үнэмлэх тогтоосон хугацаанд аваагүй 117 иргэнд зөрчил хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн. 2021-2022 оны хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн 223 материалыг прокурорын газарт хүргүүлж хянууллаа.	100

3.4	<b>Арга хэмжээ 4</b> Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100		100	Иргэн, ЭХЭУБ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх 4 заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллав.. /Цахим бүртгэлийг үнэн зөв хөтлөх, цаасан суурьт нотлох баримтыг цахим сантай тулган нягтлах, сумдын бүртгэгч нарын 2021-2022 оны бүртгэлд нэг бүрчлэн хяналт оруулах, сумдын улсын бүртгэгч нарт зөвлөн туслах ажлуудыг тусгасан бөгөөд хэрэгжилт хангалттай сайн/ Дэлгэрэнгүй тайланд тусгав.	100
	<b>Зорилт 4.</b> Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Байгуулл агын төсөв	Хувийн хэргийн тооллого, устгал	1		2	Архивын сан хөмрөгт 21041 хуудас бүхий хувийн хэргийн баяжилтыг цаг хугацаанд нь журмын дагуу хийж гүйцэтгэсэн. Архивын хувийн хэргийн тооллогыг иргэн, ЭХЭУБүргэлд хийж тайланг УБЕГазарт хүргүүлээ. Журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Тус хэлтсийн архивт хадгалагдаж байгаа хувийн хэргээс тусгаарлалтанд ялгагдсан 5600 хуудас бүхий баримтыг устгалд оруулахаар саналыг хүргүүлсэн.	100
4.1	<b>Арга хэмжээ 1</b> Улсын бүртгэлийн архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийг нэгдсэн санд цахим хэлбэрээр хөтлөх	-	-Цахим санг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн эсэх;  -Цахим санд оруулсан архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн тоо.	2500		3000	<b>Иргэний бүртгэлийн чиглэлээр:</b> Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд иргэний гэр бүлийн 1212 бүртгэлийн 3771 хуудас, иргэний үнэмлэхийн 1766 бүртгэлийн 3000 хуудас, шилжилт хөдөлгөөний 1671 бүртгэлийн 3346 хуудас, гадаад паспортын 100 бүртгэлийн 100 хуудас нийт 4749 бүртгэлийн 10217 хуудас	100

						баримтыг цахимжуулсан байна. Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулснаар цахимжуулсан баримтыг ашиглах, засварлах программын хэрэглээ сайжирч цаг хугацааг хэмнэж мэдээллийг түргэн шуурхай солилцох, дамжуулах нөхцөл боломж бүрдсэн. <b>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:</b> 440 иргэн хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 3800 хуудас хувийн хэргийг цахимжуулан мэдээллийн санд оруулсан байна. <b>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:</b> 2811 бүртгэл хийж анхны бүртгэлийн хувийн хэргийн 5490 хуудас, өмчлөх эрх шилжих 483 бүртгэлийн 2898 хуудас, барьцааны гэрээний 1254 бүртгэлийн 9170 хуудас, бусад бүртгэлээр 671 хуудас нийт 18230 хуудас цахимжуулж хэлтсийн архивт шилжүүлэв.		
4.2	<b>Арга хэмжээ 2</b> Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах		-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо;  -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100%		100%	2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллав. ЭХЭУБ-ийн архивын хувийн хэргийн тооллогыг хийж эд хөрөнгийн цахим сантай нэг бүрчлэн тулгаж тусгаарласан хуудсыг ангилан авч хаягжуулан архивын санд хадгалалт хамгаалалтын дүрэм журмын дагуу цэгцэлж хаягжуулан байршуулав. Архивын тавиур УБЕГазраас 20 сая төгрөгөөр нийлүүлэхээр шууд худалдан авалтын гэрээ байгуулав. Төрийн архивын улсын үзлэгийг дүгнэх аргачлалын дагуу гүйцэтгэлийн ханган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай сайн.	100

	<b><u>Зорилт 5.</u></b> Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.	Байгууллагын төсөв	Орон тоо бүрэн ажиллах 30 албан хаагч Мэргэшлийн зэрэг ахиулах 1 албан хаагч	26  0		30  1	2022 онд дутуу байсан 4 бүртгэгчийг УБЕГазарт санал хүргүүлж томилуулснаар тус хэлтсийн батлагдсан орон тоо 100 хувь хангагдан ажиллаж байна. ЭХЭУБүртгэгч жирэмсэн амаржсаны амралт эдэлсэн тул оронд нь шаардлага хангасан иргэнийг түр томилууллаа. Тус хэлтсийн бичиг хэргийн ажилтан мэргэшлийн зэрэг хамгааллаа.	100
5.1	<b><u>Арга хэмжээ 1</u></b> Сул ажлын байрны захиалгыг хуульд заасан хугацаанд хүргүүлж хүний нөөцийн бүрэн хангаж ажиллана		Сул ажлын байрыг мэргэжлийн боловсон хүчнээр хангасан тоо	7		3	Цагаандэлгэр, Луус сумын бүртгэгчийн орон тоо дутуу байсныг УБЕГазрын ТАСалбар зөвлөлд хүсэлт хүргүүлэн тусгай шалгалтыг 3 удаа зарлуулсан. 4 сарын 1-ний өдрийн ерөнхий шалгалтаар тус сумдад ажиллах албан хаагчдыг бэлтгэн тэнцүүлж тусгай шалгалтанд орох шалгуурыг хангасан. Батлагдсан орон тоо бүрэн ажиллаж байна. Говь-Угтаал сумын бүртгэгчийг тусгай шалгалтанд хамруулан томилуулж үүрэгт ажлыг журмын дагуу хүлээлцэн дадлагажууллаа. Тус хэлтсийн орон тоо 100 хувь хангагдан ажиллаж байна.	100
5.2	<b><u>Арга хэмжээ 2</u></b> Албан хаагчдыг эрх зүйчээр сургах, мэргэшүүлэх		Суралцаж байгаа албан хаагчдын тоо	0		3	Тус хэлтсээс сумын бүртгэгч 3, архивч 1, гэрээт ажилтан 2 тус тус эрх зүйн эчнээ ангид элсэн онлайнаар суралцаж байна.	100
5.3	<b><u>Арга хэмжээ 3</u></b> Архив, Бичиг хэргийн ажилтныг мэргэшүүлж мэргэшлийн зэрэг олгуулах		Мэргэшлийн зэрэг авсан ажилтны тоо	1		1	Бичиг хэргийн ажилтан Д.Наранцэцэгийн хувийн хэрэг, ажлын үзүүлэлт танилцуулгыг АЕГазарт хүргүүлэн ахлах мэргэшлийн зэргийг олгууллаа.	100
	<b><u>Зорилт 6.</u></b> Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй	Байгууллагын төсөв	- Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээний	100%		100%	Хяналтанд авсан тогтоол шийдвэрийн 6 заалтын хэрэгжилт 100 хувь. Тогтоосон хугацаанд хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.	100

	болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.		хувь					
6.1	<b>Арга хэмжээ 1</b> Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих.	-	-Баримт бичгийн эргэлтийн тоо; -Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	1200		1250	11 дүгээр сарын 25-ны байдлаар 635 албан бичиг явуулсан бөгөөд УБЕГ-т 229, хууль хяналтын байгууллагад 204, аймгуудад 66, бусад байгууллагад 136 албан бичиг тус тус явуулсан байна. Мөн УБЕГ-аас Able програмыг ашиглан тоон гарын үсгээр баталгаажуулан албан бичгийг илгээж байгаа нь бичиг хэргийн зардалд хэмнэлттэй байгаа боловч зарим тохиолдолд програмын алдаа гарч чирэгдэл учирч байна. Тус хэлтсийн хэмжээнд бүртгэгдсэн 543 албан бичиг ирүүлснээс хариутай 247 албан бичиг байгаа бөгөөд бичгийн барагдуулалт 100%, байна.	100
6.2	<b>Арга хэмжээ 2</b> Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.	-	-Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх;	1		2	Аймгийн тагнуулын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Наранхүү байгууллагын нууцын асуудлыг шалгаж заавар өгч ажиллалаа. Хагас жилийн байдлаар ирсэн бичиг 2, явуулсан бичиг 1. Байгууллагын нууцын тухай хуульд зааснаар хөтлөгдвөл зохих 9 журналыг бүрэн хөтөлж ажиллалаа. Улирал бүр дотоод сүлжээнд холбоотой 23 тоног төхөөрөмжийн кодыг сольж нууц үгийн бодлогыг баримтлан ажиллаж байна. Хэлтсийн 13 албан хаагчийн мэдээлэл тээгч техник, хэрэгслийн хувийн хэргийг хөтөлж хавтаслав.	100
6.3	<b>Арга хэмжээ 3</b> Нийтийн албанд шинээр томилогдож байгаа болон албан хаагчдын ХАСХОМ	-	-24 хаагчдын ХАСХОМ хугацаанд нь мэдүүлсэн тоо	22		23	Хэлтсийн 22 албан хаагч хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ алдаа зөрчилгүй мэдүүлж тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Энэ хугацаанд УБЕГ-аар ахлах	

	мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлж ажиллах. Мэдэгдэл тайлбарыг тухай бүр авч програмд оруулах						мэргэжилтэн ЭБАТ Мөнхтуяагаас албан хаагчдад онлайнаар 2 цагийн сургалт авч анхаарах асуудлыг танилцууллаа. Аймгийн ЗДТГазрын ЭБАТ-ын чиглэл олгох сургалтанд албан хаагчид онлайнаар хамрагдсан. 2022 оны эхний хагас жил шинээр томилогдсон Говь-Угтаал, Цагаандэлгэр, Луус сумдын бүртгэгч нарын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдээллийн санд орууллаа.	100
	<b>Зорилт 7.</b> Гадаад болон дотоодын бусад байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.	Бусад эх үүсвэр	Хамран ажилласан байгууллагын тоо	2		3	Тогтвортой амьжиргаа-3 төсөл 2,5 сая төгрөг, Газрын харилцаа БХБГазар 1 гэрээ 800,0 төгрөг, Дундговь хөгжил ТББайгууллага 1 хамтын ажиллагааны гэрээ 250,0 төгрөг. НҮБХХөтөлбөртэй хамтран ажиллаж ТАХ эмэгтэйчүүдийн Манлайллын хөтөлбөрт хэлтсийн дарга хамрагдан 5 байгууллагын эмэгтэйчүүд болон удирдах шатны эмэгтэй дарга нарт сургалт хийж 5,4 сая төгрөгийн дэмжлэг авсан.	100
7.1	<b>Арга хэмжээ 1</b> Зарим төрийн болон ТББайгууллага, эрх бүхий албан тушаалтанд хандаж хамтын ажиллагааг өргөжүүлэх.	-	-Санал тавьж хандсан хүсэлт, төсөл, албан бичгийн тоо - Шийдвэрлэсэн ажлын тоо, санхүүжилт	-		3	2022 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа -3” төсөлтэй хамтран хөдөөгийн багийн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг сурталчилах зөвөлгөө мэдээлэл хүргэх зорилгоор хөдөөгийн 15 суманд 2 албан хаагч ажиллаж хамтран ажиллах гэрээний дагуу шатахуун, томилолтын зардал 3,8 сая төгрөгийн дэмжлэгийг авлаа. ГХБХБГазартай хамтран хаягжуулалтын санг цэгцлэх, сумдад кадастрын бүртгэлтэй хамт явж улсын бүртгэл хийж уг үйл ажиллагаанд 2 сумыг хамруулан ажиллалаа. 2. Аймгийн ГБХЗХГазартай	100

							<p>хамтран ажиллаж 12 хосын гэрлэлтийг ёслол төгөлдөр баталж санхүүжилт 1200,0 төгрөгийн бодит дэмжлэгийг авлаа.</p> <p>3. Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Сайнцагаан сумын бүртгэгч Ш.Чулуун, Иргэний бүртгэлийн улсын бүртгэгч Ё.Батбаяр нар тус бүр 10,0 сая төгрөгийн орон сууцны буцалтгүй дэмжлэгийг авч нийт 20,0 /хорин сая/ төгрөгийн орон сууцны тэтгэлэгт албан хаагчдыг хамрууллаа.</p>	
7.2	<p><b><u>Арга хэмжээ 2</u></b> Аймаг, сумдын ЗДТГазартай хамтран ажиллах.</p>	-	-Сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг авсан эсэх	-		1	<p>Аймгийн ЗДТГазарт ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар санал төсөл боловсруулан хүргүүлснээр тус хэлтсийн ажлын байранд урсгал засвар хийх 7,7 /долоон сая долоон зуун мянга/-н төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүллээ. Говь-Угтаал сумын сүлжээний төхөөрөмж шинэчилэх зардалд 400,0 төгрөгийн дэмжлэг авч бүрэн шинэчилж ажиллагаанд орууллаа. Дэрэн, Өлзийт, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын ЗДТГазартай хамтран ажиллаж шатахуун хоол унааны зардлыг /500,0 төг/ шийдвэрлүүлэн малчдын өдөрлөгт оролцсон 850 иргэнд Тоон гарын үсэг болон бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилан үйлчилгээ үзүүллээ. Эрдэнэдалай сум, Дэрэн сумдад төлбөрийн Гэрэгэ системийг суурьлуулах хөрөнгийн асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бүрэн шийдвэрлүүллээ. Орон нутгаас ажлын байран дээр 16,6 сая төгрөгийн дэмжлэг авсан байна</p>	100



7.3	<b><u>Арга хэмжээ 3</u></b> Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах.	-	-Албан хаагчдын хамралт	80%		100%	Албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулах захиалгыг аймгийн ЭМГазарт өгч 9- 11 дүгээр саруудад 100 хувь хамрууллаа. Адаацаг сумын улсын бүртгэгч Э.Ариунбилэг Улаанбаатар хотын эмнэлэг ковидын дараах иж бүрэн шинжилгээнд хамрагдаж 690 мянган төгрөгийг эрүүл мэнддээ зарцуулсан байна. Мөн Иргэний улсын бүртгэгч Ё.Батбаяр нь эрүүл мэндийн цогц шинжилгээг өгч 160.0 мянган төгрөг, Ш.Нарангэрэл нь "Энх ундарга" мэдрэлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэн 300 мянган төгрөгийг эрүүл мэндээ зарцуулсан.Иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч Б.Сайхантуяа, Бичиг хэргийн ажилтан Д.Наранцэцэг, хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал нар иж бүрэн шинжилгээнд хамрагдсан байна.	100
	<b>Зорилт 8.</b> Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	Байгуулл агын төсөв	Аудитын дүгнэлт Өр авлага үүссэн тоо	0		0	Зөрчилгүй дүгнэлттэй, өр авлага үүсгээгүй хуулийн хүрээнд ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
8.1.	<b><u>Арга хэмжээ 1</u></b> Байгууллагын санхүүгийн ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах.	Урсгал төсөв 398.8 сая төгрөг	-Санхүү, төсвийн удирдлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон тайланг хуульд заасан хугацаанд нь дээд газарт хүргүүлэх; -Санхүүгийн тайланг аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулах; -Санхүүгийн сахилга, батыг хангах, өргүй,	12		12	УБЕГ-т төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үнэт цаасны тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Е-тайланд байршуулсан. 1 -ээс 11-р сарын Нийгмийн даатгалын тайланг НДХ-т хүргүүлсэн. 2021 оны 4-р улирал болон 2022 оны 1-3 р улирлын татварын тайланг Татварын хэлтэст цахимаар гаргаж баталгаажуулсан. УБЕГ-ын Даргын тушаалаар үндсэн 28, гэрээт албан хаагч 2, нийт 30 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.	100

			зөрчилгүй ажилласан байх.			<p>Тус хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар 2022 оны 1 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.</p> <p>УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст тус хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт хуулийн хугацаанд нь хүргүүлж аудитлагдсан санхүүгийн тайлан ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн. 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг УБЕГ-ын СААХ-т Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу улирал бүр, дараа сарын 15-ны дотор хуулийн хугацаандаа хүргэгдэж нэгтгэгдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 2-р сард 2021 оны жилийн эцсийн өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг нөхөж хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</p> <p>МУЗГ-ын 2020 оны 1-р сарын 8-ны өдрийн №9 тогтоол, УБХ-ийн Даргын 2022 оны 5-р сарын 23-ны А/07 тоот тушаалаар 5-р сарын 23-28 өдрүүдэд үндсэн хөрөнгийн улсын тооллого хийгдэж, тооллогоор үндсэн хөрөнгийн илүүдэл, дутагдал илрээгүй. ТӨБЗГ-аас тус хэлтсийн 2021 оны Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ болон 2022 оны улсын тооллогын дүнд маш сайн буюу А /95/ үнэлгээ өгсөн. Хагас жилийн бараа материалын тооллогыг Хэлтсийн Даргын 2022 оны 6-р сарын 21-ны А/10 тоот тушаалаар тооллогын</p>
--	--	--	---------------------------	--	--	--

							комисс тооллого хийж, тооллогоор илүүдэл, дутагдал илрээгүй.	
8.2.	<p><b><u>Арга хэмжээ 2</u></b></p> <p>Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, цахим хуудаст байршуулах, тайлан гаргах.</p>	-	<p>-Гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах;</p> <p>-Санхүүгийн тайланд тусгах;</p>	12		12	Шилэн дансны цахим хуудсаар сар бүр мэдээлэн ажиллаж байна. УБЕГ-аас орон нутаг дахь хэлтсүүдэд “Эд хөрөнгө, иргэн, хуулийн этгээдийн хувийн хэрэг хадгалах нягтруулсан шүүгээ бэлтгэх арга хэмжээ” –тэй холбоотой шууд худалдан авалтын эрх шилжүүлсэнтэй холбоотой 62,400.0 мянган төгрөгийн санхүүжилт 11 сард нэмж орсон болно. Хуулийн дагуу ажлын хэсэг томилж сонгон шалгаруулалт хийх бэлтгэлийг ханган мэдээллийн ил тод байдлын шалгуурыг ханган ажиллаж байна.	100
8.3	<p><b><u>Арга хэмжээ 3</u></b></p> <p>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх</p>	-	<p>Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, байршуулах ёстой мэдээллийг хугацаандаа үнэн зөв, бүрэн байршуулах;</p> <p>-Тайланг улирал тутам, хугацаанд нь УБЕГ-т илгээх</p>	145		145	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 01 өдөр хүртэлх хугацаанд нийт 133 мэдээлэлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 133 мэдээллийг хугацаа хоцролгүй үнэн зөв, бүрэн байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.	100
8.4	<p><b><u>Арга хэмжээ 4</u></b></p> <p>Бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хэрэгжүүлэх</p>		<p>Хагас бүтэн жилийн тооллогыг зохион байгуулж үр дүнг санхүүгийн тайланд тусгах</p>	2		2	Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2022 оны 2-р сарын 28 өдөр хуралдаж, анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй, хуучин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автотээврийн хэрэгслийг актлах дүгнэлт гаргасан. 2022 оны 3-р улиралд УБЕГ-ын СААХ-т авто тээврийн хэрэгсэл 1, машин тоног төхөөрөмж 8, тавилга эд хогшил 4, нийт 3 нэр төрлийн 13 ширхэг	100

							24,153.8 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө актлах санал хүргүүлсэн. МУЗГ-ын 2020 оны 1-р сарын 8-ны өдрийн №9 тогтоол, УБХ-ийн Даргын 2022 оны 5-р сарын 23-ны А/07 тоот тушаалаар 5-р сарын 23-28 өдрүүдэд үндсэн хөрөнгийн улсын тооллого хийгдэж тооллогоор илүүдэл, дутагдал илрээгүй. Жилийн эцэсийн тооллогын ажлын хэсэг томилогдон үүрэгт ажилдаа орсон болно.	
8.5	<b>Арга хэмжээ 5</b> Цахим төлбөрийн хэрэгсэл болох Гэрэгэ машины ашиглалтыг боловсронгуй болгох, хэлтсийн орлогын дансуудыг Гэрэгэ системд холбуулах		Үйлчилгээний хураамжийг цахим төлбөрийн системээр дамжуулан хэлтсийн Төрийн банкин дахь орлогын дансуудыг Гэрэгэ системтэй холбож орлогыг төвлөрүүлэх	1		2	2022 оны 3-р сард УБХ-ийн үйлчилгээний орлогын Төрийн банкин дахь 3, Татварын хэлтсийн төрийн сан дахь улсын тэмдэгтийн хураамжийн 1, хүү торгуулийн орлогын 1, нийт 5 данс бүрэн холбогдсон. 57,812.2 мянган төгрөгийг улсын төсөвт 100 хувь төвлөрүүлсэн.	100
8.6	<b>Арга хэмжээ 6</b> Байгууллагын ахмадын санг журмын дагуу нэмэгдүүлэх, зарцуулах, ахмадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	Ахмадын сан	<ul style="list-style-type: none"> <li>- Ахмадын сангийн орлого төвлөрүүлэлт журмын дагуу хийгдсэн байх</li> <li>- Ахмадын нийгмийн асуудлыг 2 удаа шийдвэрлэх</li> </ul>	2		2	Засгийн газрын 2017 оны 197 тогтоолын дагуу төсвийн хэмнэлтээс цалингийн зардлын 3 хүртэлх хувь гэсэн заалтын дагуу 2,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Байгууллагын 5 ахмадад 2022 оны сар шинийн баяраар тус бүр 150,0 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, 5-р сард өндөр настан П.Тогосмаад өрхийн тариалан эрхлэхэд нь зориулж 3,000.0 төгрөгийн 1 удаагийн дэмжлэг олгож, нийт 3,750.0 мянган төгрөгийг Ахмадын сангаас зарцуулсан. Дансны үлдэгдэл 1,7 сая төгрөг	100
	<b>Зорилт 9.</b> Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ,	Байгууллагын төсөв	Хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дотоод хяналтыг 1 удаа хийнэ	-		2	2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэлтсийн даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон хяналт үнэлгээ хийж 92,0 хувийн дундажтай үнэлсэн. 2022 оны	100

	дотоод аудит тогтмол хийж, үр дүнг сайжруулна.						жилийн эцэсийн үнэлгээг хэлтсийн даргын 12 дугаар сарын 05-ны өдрийн А/13 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг хүн тус бүрээр үнэлж тайлангийн хурлыг хийлээ.	
9.1.	<b>Арга хэмжээ 1</b> Дэд төлөвлөгөөнүүдийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Ил тод байдал - Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр - Авлига -Терроризм - Сургалт - Стратеги төлөвлөгөө - ЗДҮАХөтөлбөрийн биелэлт - Сайдын гэрээний холбогдох заалтын биелэлт - Нэг иргэн нэг бүртгэл үндэсний хөтөлбөр	100%		100%	"Нэг иргэн-Нэг бүртгэл" хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь,, Терроризмтой тэмцэх төлөвлөгөөний хэрэгжилт 100, Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт 100, Хүний эрхийн төлөвлөгөөний хэрэгжилт 90, Нийгмийн баталгааг хангах дэд төлөвлөгөөний хэрэгжилт 100, Жендерийн дэд төлөвлөгөөний хэрэгжилт 100, Гэм хэрэгээс урьдчилан сэргийлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай хэрэгжүүлэн ажиллав. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарь, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллав. Хэрэгжилтийн дундаж 90 хувь	95
9.2.	<b>Арга хэмжээ 2</b> Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сайдын шуурхай хуралдаан, Ерөнхий газрын дарга, Даргын зөвлөлийн хурал, Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаварыг хангаж ажиллана.	-	-Үүрэг даалгаврын хөтөлгөө, хяналтанд авсан тоо - Үүрэг даалгаврын хэрэгжүүлэлтийн хувь	100%		100%	Иргэний улсын бүртгэлийн газраас 13, Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас 5, Хяналт шалгалтын газраас 3 нийт 21 үүрэг даалгаварыг хугацаанд нь хэрэгжүүлж хариу хүргүүлэн ажиллалаа. Үүрэг даалгаврын тусгай журнал хөтөлж хяналтанд авч байгаа бөгөөд ERP нэгдсэн систем дээр цахим бүртгэлээр хяналт тавьж хэвшсэн.	100
9.3.	<b>Арга хэмжээ 3</b> Хэлтсийн албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд үнэлгээ	-	- Хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийн талаар даргын зөвлөлийн хурлаар нэгж, албан хаагч бүрээр сонсгол	1		2	Хэлтсийн даргын 2022 оны 06 сарын 07-ны өдрийн А/08 тоот тушаалаар ажлын хэсэг томилогдон албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх, анхаарах асуудлын талаар зөвлөмж боловсруулж даргын зөвлөлийн	100

	өгөх тайлангийн хурал сонсгол хийх		хийх, зөвлөмж өгөх				хурлаар хэлэлцэн албан хаагч бүрт хурлын тэмдэглэлээр үүрэг өгч тайлангийн чанарт анхаарах, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах талаар зааварчилгааг өглөө. Аймгийн ХШҮнэлгээний ахлах мэргэжилтэнгээс зааварчилгааг бүх албан хаагчдад өгч стандартад нийцүүллээ.	
9.4	<b>Арга хэмжээ 4</b> 2022 оныг "Хүний хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Хэлстийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх		<ul style="list-style-type: none"> <li>- Ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдлын тоо</li> <li>- Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчийн тоо</li> <li>- Хувь хүний хөгжил, ёс зүйн чиглэлээр албан хаагчдад сургалт зохион байгуулсан тоо</li> </ul>	0		0	<p>Хэлтсийн даргын 2022. 03. 10 өдрийн А/04 тоот тушаалаар ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулав. Хэлтсийн алба хаагчидтай ёс зүйн гэрээг шинэчлэн байгуулж хувийн хэрэгт авав. Хэлтсийн дотоод үйл ажиллагаанд тавих хяналт болон ёс зүйн зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан. Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Ш.Нарангэрэлийг нэг удаа хуралаар оруулж үйл ажиллагаа, харилцаа хандлагын чиглэлээр зөвлөмж өгч цаашид үйл ажиллагаандаа анхаарах асуудлын талаар хэлэлцлээ. Луус, Цагаандэлгэр сумдын шинээр томилогдсон улсын бүртгэгч нартай ёс зүйн гэрээ байгуулсан.</p> <p>-Өргөдөл гомдол 0</p> <p>-Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагч: ИУБүртгэгч Ш.Чулуунжаргал, ЭХЭУБТасгийн дарга Ш.Нарангэрэл сахилгын сануулах шийтгэл 2</p> <p>-Хувь хүний хөгжил, ёс зүйн чиглэлээр сургалт 3 удаа зохион байгуулсан.</p> <p>2022 онд Байгууллагын соёлыг бий болгох, Хандлагаа өөрчилье цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа. Ёс зүй Хувь хүний хөгжлийг дэмжих чиглэлээр</p>	100

							Аймгийн хэмжээнд уралдаанд амжилттай оролцож дүгнэгдэв.	
9.5	<b>Арга хэмжээ 5</b> Хэлтсийн гадна болон дотор орчинд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх		Хариуцсан талбайн ногоон байгууламжийн ургалтын хувь Дотор орчны цэцэгжүүлэлт хийх	30  0		30  30	2021 онд 30 мод тарьсан бөгөөд модны ургац арчилгааг үргэлжлүүлэн хийж хаврын нөхөн тарилтыг 5 сард 48 суулгац суулган нийт 78 модны арчилгаа усалгааг хийж байна. Усны мөнгө 180,0 төгрөгийг зарцуулсан. Мөн хэлтэс дотроо тасалгааны цэцэг тарих аян өрнүүлж 200,000 төгрөгийг өрөө тасалгаагаа цэцэгжүүлэх аянд зарцуулаад байна. Аймгийн төв талбай Чагдаржавын хөшөөний орчинд болон цэцгийн мандалд үр суулгаж тогтмол усалгаа арчилгааг хийж байна. Уг үйл ажллагаанд 190,0 төгрөгийн санхүүжилтийг хамтын сангаас зарцуулаад байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд 570,0 төгрөг зарцуулсан байна.	100
9.6	<b>Арга хэмжээ 6</b> Дундговь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах	Бусад эх үүсвэр	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	0		10,0 /арван сая/	Нэг цэгийн үйлчилгээний танхимд аймгийн ЗДТГазартай хамтран засвар хийхээр тооцооллыг хүргүүлж шалыг бүрэн солих 7,7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж Тааз, гэрэлтүүлэг хананы зардалд 3,0 сая төгрөгийг зарцуулж, дотор хаягжуулалт, сандлыг жигдлэн үйлчилгээний танхимын өнгө үзэмжийг сайжрууллаа.	100
9.7	<b>Арга хэмжээ 17</b> Цахим үйлчилгээний хэрэглээний талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, сургах		Сургалт мэдээлэл өгсөн иргэдийн тоо	80		1500	Бүртгэлийн нээлттэй утсаар 2022 онд 1206 иргэн зөвлөгөө мэдээлэл авсан бөгөөд Поро бона сэдэвт тусгай чиг үүргийн байгууллагуудын нээлттэй мэдээллийн өдөр болон 15 сумдын малчдын өдөрлөгт оролцож e-mongolia төрийн үйлчилгээний	100

							нэгдсэн порталийг нийт 972 иргэнд сурталчилж, утсанд нь тус e-mongolia аппликейшн суулгаж бүртгэлийн үйлчилгээ авах аргачлалыг зааж туршилт явуулж, иргэний үнэмлэхний лавлагаа авахыг сургав.. E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системээр иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 235 иргэнд иргэний үнэмлэх захиалан олгосон байна.	
9.8	<b>Арга хэмжээ 8</b> Хог ангилан ялгах сав хийж байршуулах	Бусад эх үүсвэрээр	Хогийн сав хийгдсэн байх	0		1	Нэг цэгийн үйлчилгээний танхимд хог ангилан ялгаж хаях хогийн савыг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хийж таних тэмдэгтэйгээр байршуулан ашиглаж байна.	100
9.9	<b>Арга хэмжээ 9</b> Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт олох		Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо	0		1	Гадаадын байгууллагад хүргүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй. Дундговь хөгжил төрийн бус байгууллагатай хамтран “Дундговь аймгийн иргэдийг Төрийн үйлчилгээг цахим орчинд авах чадварыг нэмэгдүүлэх нь” төсөл бичиж хянуулсан. НҮБХХӨтөлбөр Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрт аймгаас 1 хамрагдаж /хэлтсийн дарга/ хөтөлбөрийн хүрээнд 5,4 сая төгрөгийн сургалтыг аймгийн байгууллагуудад өгч хамтран ажиллалаа.	70
9.10	<b>Арга хэмжээ 10</b> Вэб сайны ашиглалт, хөгжүүлэлтийг тогмолжуулж мэдээ мэдээллийг тогтмол оруулж хэвших		Оруулсан мэдээний тоо	46		50	Мэдээлэл технологийн ажилтан Г.Алтан-Од ажил үүргийн хуваарийн дагуу байгууллагын цахим хуудас хөгжүүлэлт, мэдээллийн ил тод байдлыг хариуцан ажиллаж байна. Энэ хугацаанд аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан мэдээллийн технологийн ажилтнуудад хийгдсэн 2 удаагийн сургалтанд сууж мэдлэгээ ахиулсан. Хэлтсийн вэб сайтад текстэн мэдээ 110, видео мэдээ 22	100



							<p>бэлтгэн хөгжүүлэлт хийлээ. Үйлчилгээний сар бүрийн нэгтгэсэн тоон мэдээгээр 1 сараас 11-р сарын инфографик мэдээлэл бэлтгэн сар бүрийн 28-ны дотор олон нийтэд хүргэн, вэб сайтад байршууллаа.</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.19-д заасан арга хэмжээг заасан хугацаанд вэб сайт, фэйсбүүк пэйж хуудсанд нийт 150 мэдээг бэлтгэн, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор ханган ажиллалаа.</p>
	Дундаж үнэлгээ						

Төлөвлөгөөг хянасан:

(албан тушаал) ..... / / (огноо)

Тэмдэг 2022.06.30

Төлөвлөгөө тайлагнасан: Төсвийн Шууд захирагч